



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024. 02. 19.

№ 01

Борхойн тал

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.14 дэх заалт, Компанийн дүрмийн 4-р зүйлийн 4.4 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эчнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Э-Транс Ложистикс” ХК-ны 2023 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6 төгрөгөөр тооцон 46,200,000 хувьцаанд нийт 277,200,000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тасалбар болгосугай.

3. Ногдол ашиг хуваарилах ажлыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан зохион байгуулж 2024 оны 12 сарын 31-ний дотор тухайн компанийн дансанд шилжүүлж дуусгах ба ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Энхболдод даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024.02.19.

№ 02

Борхойн тал

Гүйцэтгэх захирлыг томилох тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 76-р зүйлийн 76.1.8, 83-р зүйлийн 83.4, 83.6 Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.19.5 дах заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эцнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн “Э-Транс Ложистикс” ХК-ны Гүйцэтгэх захирлаар Чулууны Энхболд / регистрийн дугаар: НИИ67022618 /-ыг томилсугай.

2. Гүйцэтгэх захирал Ч.Энхболдод компанийн нэрийн өмнөөс Монгол улсын хууль, тогтоомж, компанийн дүрэм, хөдөлмөрийн гэрээнд заасан эрхийн хүрээнд гэрээ хэлцэл байгуулах, итгэмжлэлгүйгээр төлөөлөх, компанийн эрх ашигт нийцсэн албан бичиг баримтад компанийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах эрхийг үүгээр олгосугай.

3. Гүйцэтгэх захирал Ч.Энхболдтой байгуулах хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээг байгуулан, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулахыг Э-Транс ложистикс ХК-ны Захиргаа, дотоод ажлын алба / С.Ганбат /-д даалгасугай.

4. Гүйцэтгэх захирлын мэдээллийг Улсын бүртгэлд бүртгүүлж компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлэх, Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэх, холбогдох сайтуудад мэдээллийг байршуулахыг Гүйцэтгэх захирал / Ч.Энхболд /-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024. 03. 11.

№ 03

Борхойн тал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн эчнээ хурлын саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 30-ний өдрийн 10 цагт “БиДиСек ҮЦК” ХК-ийн <https://aqm.mn/> цахим системээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
 - b. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
 - c. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
 - d. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлах
 - e. ТУЗ-ийн 2024 оны цалин урамшууллын төсөв батлах
 - f. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - g. Ногдол ашгийн талаарх шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ийг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 18 дах өдөр буюу 2024 оны 04 сарын 01-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 3 дахь өдөр буюу 2024 оны 03 сарын 14-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сониноор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2024 оны 03 сарын 29-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд “БиДиСек ҮЦК” ХК-ийн төв оффис, компанийн цахим хуудас, Facebook дэх пэйж болон хурлын зар дахь цахим хаяг, утсаар хурал зохион байгуулах комиссын дарга С.Ганбат, Б.Онон нараас авч танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ийн агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай .
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ийг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2024 оны 04 сарын 30-ний 10:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Э.Батболд, хурал зохион байгуулах комиссын даргаар С.Ганбат, гишүүнээр Б.Онон, тооллогын комиссын даргаар М.Саранжаргал, гишүүнээр Б.Хонгор нарыг тус тус томилсугай.
- 10.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
- 11.ХЭХ хуралдуулах ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Ч.Энхболдод үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД/



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024. 03. 25

№ 05

Борхойн тал

Журам, заавруудыг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.13, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145-р тогтоол, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ны гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 09-ний А/58 дугаар тушаалыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах дараах журмуудад өөрчлөлт оруулан хавсралтаар баталсугай.

- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам;
- Аудитын хорооны журам;
- Нэр дэвшүүлэх хорооны журам;
- Цалин урамшууллын хорооны журам;
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэх журам;
- Мэдээллийн үйл ажиллагааны журам;
- ХЭХ-ийн зар хүргэх журам;
- ХЭХ-ийн үйл ажиллагааны журам;
- Нарийн бичгийн үйл ажиллагааны журам;

2. Журмын дагуу компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Энхболдод даалгасугай.

3. Өөрчлөлт оруулсан болон бусад баталсан журмуудыг Хөрөнгийн бирж, Компанийн засаглалын үндэсний зөвлөл болон компанийн цахим хуудсуудад оруулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Ганбатад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Э. БАТБОЛД





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024. 07. 05

№ 6

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, компанийн дүрмийн 3 дахь хэсгийн 3.26 дахь заалт, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Энхболдын Батболдыг улируулан сонгосугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Батболдод холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024.07.05

№ 7

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
дэргэдэх хороодыг байгуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Э-Транс Ложистикс хувьцаат компанийн дүрмийн 3.32, холбогдох журмуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

А. Нэр дэвшүүлэх хороо

1. Ч.Оргил / ТУЗ-ын хараат бус гишүүн /, хорооны дарга,
2. Ж.Энхтулга / ТУЗ-ын хараат бус гишүүн /,
3. А.Бат-Орших / ТУЗ-ын ердийн гишүүн /,

Б. Аудитын хороо

1. Ж.Энхтулга / ТУЗ-ын хараат бус гишүүн /, хорооны дарга,
2. Х.Батхишиг / ТУЗ-ын хараат бус гишүүн /,
3. Б.Лхагвадорж / ТУЗ-ын ердийн гишүүн /,

В. Цалин урамшууллын хороо

1. Х.Батхишиг / ТУЗ-ын хараат бус гишүүн /, хорооны дарга,
2. Ч.Оргил / ТУЗ-ын хараат бус гишүүн /,
3. Д.Даянбилгүүн / ТУЗ-ын ердийн гишүүн /

2. Хороодыг хууль, журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулан хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байхыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Э.БАТБОЛД





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024. 11. 18

№ 09

Борхойн тал

Журам хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйл, 55 зүйлийн 55.2, 55.3, 55.4 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлшлээ 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 3.19.4, 3.19.15 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. "Э-Транс ложистикс" ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч "Э-Транс" ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хавсралтаар батлагдсан журмын дагуу хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.

2. "Э-Транс ложистикс" ХК-ийн бусад хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг Хавсралт №1-ээр баталсугай.

3. Нэгж хувьцааг эргүүлэн худалдан авах зах зээлийн үнийг хувьцааны сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш, зах зээлийн ханшийг харгалзан 118.08 /нэг зуун арван найман төгрөг найман мөнгө/ төгрөг байхаар тогтоосугай.

4. Энэхүү тогтоолд заасан үнэ, журмын дагуу худалдан авахыг хяналтын багцын хувьцааг эзэмшигч "Э-Транс" ХХК-д зөвшөөрсүгэй.

5. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах өдрийн уг эрх үүссэн өдөр буюу 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөр тогтоосугай.

6. Энэхүү шийдвэрийн талаарх мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлэн, хувьцаа эзэмшигчдэд "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 18-ны болон 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлан мэдэгдсүгэй.

7. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах зарын загварыг Хавсралт №2-оор баталсугай.

8. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах хугацааг олон нийтэд анх

мэдэгдсэнээс хойш 30 өдөр буюу 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдрийг дуустал байхаар тогтоосугай.

9. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг Үнэт цаасны компани болон "Э-Транс ложистикс" ХК-д бичгээр, цаасан болон цахим хэлбэрээр энэхүү тогтоолын 8-д заасан хугацаанд хүлээн авахаар тогтоосугай.

10. Энэхүү шийдвэрийг сонирхлын зөрчилгүй Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталсугай.

11. Энэхүү тогтоол болон хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хууль, тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Энхболдод үүрэг болгосугай.

12. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигч болон холбогдох байгууллагуудад хууль, тогтоомжид заасны дагуу хүргүүлэх, хувьцаа эзэмшигчийн шаардах эрхийг хэрэгжүүлэх шаардлагыг хүлээх авах, тайлан, мэдээлэл хүргэн ажиллахыг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Ганбатад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Х. БАТХИШИГ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫГ КОМПАНИАС ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журам (цаашид “Журам” гэх)-аар “Э-Транс ложистикс” ХК (цаашид “Компани” гэх)-ийн хяналтын багц эзэмшигч болох “Э-Транс” ХХК-аас бусад хувьцаа эзэмшигчд (цаашид “Бусад” хувьцаа эзэмшигч гэх)-ээс өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компани эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах, шаардах эрхээ хэрэгжүүлэх, Компани нь Монгол улсын Компанийн тухай хуулийн 53, 54 дугаар зүйлд заасан журмын дагуу шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Компанийн хяналтын багц эзэмшигч “Э-Транс” ХХК-ийн хувьцаа худалдан авсан өдөр буюу 2024 оны 10 сарын 16-ны өдрийг хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүссэнд тооцно.
- 1.3 Компани хувьцаа эзэмшигчийн шаардлагаар эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаас хувьцааны сүүлийн 6 сарын жинлэсэн дундаж ханшийг харгалзан 118.08 /нэг зуун арван найман төгрөг найман мөнгө/ төгрөг байхаар тогтоосон болно.
- 1.4 Компани нь энэхүү журмын дагуу хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авахыг хяналтын багц эзэмшигч “Э-Транс” ХХК-д зөвшөөрсөн болно.

ХОЁР.БУСАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2-д заасны дагуу бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй.
- 2.2 Бусад хувьцаа эзэмшигчид нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр анх мэдэгдсэнээс хойш 30 өдөр буюу 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдрийг дуустал Үнэт цаасны компаниуд болон “Э-Транс ложистикс” ХК-д бичгээр, цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.3 Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-д заасны дагуу хувьцаагаа эргүүлэн авахыг шаардсан хувьцаа эзэмшигч нь шаардлагадаа эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, эргүүлэн авахыг шаардаж буй хувьцааны тоо, төрөл, эргэж холбогдох утасны дугаар зэрэг хувийн мэдээллийг ирүүлэхийг зөвшөөрч мэдээллийг бүрэн оруулах үүрэгтэй.
- 2.4 Хувьцаа эзэмшигч нь Компанид хувьцаа худалдах тухай шаардлагыг бичгээр гаргахдаа холбогдох мэдээллийг үнэн зөв гаргах үүрэгтэй ба шаардлагад худал мэдээлэл оруулсантай холбогдуулан гарах үр дагаврыг Компани хариуцахгүй болно.



ГУРАВ.КОМПАНИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 3.1 Компаниас шаардах эрх үүссэн талаарх шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын дагуу өдөр тутам хэвлэгдэн гардаг сонин, орон даяар нэвтрүүлэг хүргэдэг телевиз, Компанийн өөрийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус бүр 2-оос доошгүй удаагийн давтамжтайгаар буюу 2024 оны 11 дүгээр сарын 18-ны болон 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлэх үүрэгтэй.
- 3.2 Энэ журмын 2.2-д зааснаар Компанид хүргүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй.
- 3.3 Хувьцаа эзэмшигч Компанид эргүүлэн худалдах хувьцааны үнийг зах зээлийн үнээс бодит бус, өндрөөр үнэлэн шаардах эрхийн хүсэлтийг ирүүлсэн тохиолдолд Компани хувьцааг худалдан авахаас татгалзах эрхтэй.
- 3.4 Компани нь хувьцаа эзэмшигчийн хувийн мэдээллийг хамгаалж бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

ДӨРӨВ.ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШААРДЛАГААР КОМПАНИ ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

- 4.1 Компанийн хяналтын багц эзэмшигч "Э-Транс" ХХК-ийн хувьцаа худалдан авсан өдөр буюу 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг хувьцаа эзэмшигч компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүсэнд тооцно.
- 4.2 Компани нь хувьцаа эзэмшигчдэд Компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн тухай мэдэгдлийг энэхүү журмын 3.1-т заасны дагуу хүргэнэ.
- 4.3 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг энэ журмын Хавсралт №1-д заасан маягтын дагуу бичгээр гаргах бөгөөд Үнэт цаасны компаниуд болон "Э-Транс ложистикс" ХК-д бичгээр, цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 4.4 Хувьцаа эзэмшигч нь энэ журмын 2.2-д заасны дагуу 30 өдрийн дотор шаардах эрх хэрэгжүүлэх шаардлагыг (Хавсралт №1-д заасан маягтын дагуу) ирүүлээгүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтайд тооцно.
- 4.5 Энэ журмын 2.2-д заасны дагуу ТУЗ-өөс тогтоосон буюу Компанийн тухай хуулийн 54.5-д заасан хугацаанд Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй буюу хүсэлт гаргаагүй хувьцаа эзэмшигч нь гомдол гаргах эрхгүй байна.
- 4.6 "Э-Транс" ХХК-аас энэхүү журмын 2.2-д заасан хугацаанд хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардсан хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон хувьцааны үнээр тооцон гаргаж, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь дансанд байршуулна.
- 4.7 Хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардсан хувьцаа эзэмшигчдийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн хувьцаа эзэмшигчийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлснээр тухайн хувьцаа эзэмшигчийг компанийн хувьцаа эзэмшигчээс хасагдсанд тооцно.

Хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж
авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын



Хавсралт №1

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ НЬ ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН
АВАХЫГ КОМПАНИАС ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 54, 55-р зүйлд заасаны дагуу өөрт
үүссэн шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа тул төвлөрсөн хадгаламж дахь
..... тоот дансанд буй "Э-Транс ложистикс" ХК-ийн
..... ширхэг хувьцааг эргүүлэн авахыг компанид зөвшөөрч,
ногдол хувийн мөнгийг авах хүсэлт гаргаж байна.

Хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Регистрийн дугаар:

Оршин суугаа хаяг:

Холбоо барих утас:

Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг:

Гарын үсэг:

Хүсэлт гаргасан огноо:

..... компани

Хүсэлтийг хүлээн авсан огноо

Хүсэлт хүлээн авсан компанийн ажилтан

"ҮЦТХТ" ХХК


"ҮЦТХТ" ХХК-д хүлээн авсан огноо

Хүсэлт хүлээн авсан ХӨЭБКА-ны ажилтан

Гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан

Хянасан ХӨЭБКА-ны дарга

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 22 тоот
тогтоолын Хавсралт № 2



“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН АНХААРАЛД

"Э-Транс ложистикс" ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч "Э-ТРАНС" ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр "Э-Транс ложистикс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн ээлжит бус хурлаар Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасныг үндэслэн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн тус шийдвэрээр "Э-Транс" ХХК-д хувьцаа худалдан авах зөвшөөрлийг олгон уг ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна.

Эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнэ: 118.08 төгрөг

Хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүссэн өдөр:
2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа:
2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа:
2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийг дуустал

Хүсэлт хүлээн авах хэлбэр:

Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг Үнэт цаасны компани болон "Э-Транс ложистикс" ХК-д бичгээр, цаасан болон цахим хэлбэрээр

Бүрдүүлэх бичиг баримт:

1. Хувьцаа эзэмшигчийн хувьцаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах хуудас
2. Хувьцаа эзэмшигч иргэн:
 - Иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
3. Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд:
 - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - Шууд төлөөлөх эрх бүхий этгээд эсвэл итгэмжлэл бүхий этгээд өөрийн иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - Компанийн тамга

Холбоо барих мэдээлэл:
Утас: 90999494, 75551919

Цахим шуудан: etranslogistics@hotmail.com, etranslogistics999@gmail.com

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж 27/1, "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн төв байр.

Хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1-р баг, Төмөр замчдын өргөн чөлөөний гудамж, 04-411 тоот.

Дээрх хүсэлтийг хувьцаа эзэмшигч нь "Э-Транс ложистикс" ХК-д гаргаснаар хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн хувьцаа эзэмшигчийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлж, хувьцаа эзэмшигчээс хасагдсанд тооцно.